



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/АШ

Булган сум

Газар эзэмших эрх хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газар (РД:9012419)-ын Булган сум 6 дугаар баг С.Удвалын дүгээр гудамж 104 тоотод байршилтай 6308009557 нэгж талбар бүхий нийтийн орон сууцны зориулалтаар эзэмшиж буй 11677 м2 газраас 98 м2 газрыг "Төрийн банк" ХК (РД:5341469)-д шилжүүлж нийт 898 м2 газар, үлдсэн 11579 м2 газрыг "Аймгийн Засаг даргын Тамгын газар"-т тус тус эзэмшүүлсүгэй.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газар болон Төрийн банк ХК-тай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/77 дугаар захирамж, 2023 оны А/548 дугаар захирамжийн аймгийн Засаг даргын Тамгын газартай холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ